

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244803

ОЮУТАН СУРАЛЦАГЧДЫН ЯРИХ ЧАДВАРЫГ
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Ч.Баттулга

Товч агуулга: “Ярианы хэл” буюу аман хэлэхүйн төрөл зүйлийг хэрэглээний хэл шинжлэлийн талаас нарийвчлан судлах шаардлага гарч байна. Улмаар сургалтад ашиглаж болохуйц төрөл зүйлийг тогтоож, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад багтаах байдлаар оюутан суралцагчдын ярих чадварыг хөгжүүлэх боломжтой юм. Ялангуяа, орчин үеийн хүмүүсийн зайлшгүй сурч дадах ур чадварын нэг болсон “Нийтэд зориулсан яриа” /Public speaking/, мөн албан болон албан бус яриаг энэ чиглэлийн хичээлийн суралцахуйн зорилго, зорилттой уялдуулан хэрхэн заан сургах талаар энд өгүүллээ.

Түлхүүр үг: Үгэн бус харилцаа, аман хэлэхүй, ярианы хэл, Linguistic Registers, хэлэхүйн соёл, албан яриа, Риторик, Public speaking, ерөөл, хундаганы үг, эмгэнэлийн үг

Хэл нь хүмүүсийн харилцааны хэрэгсэл юм. Харилцаа нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. Үгэн харилцаа (Verbal communication)
2. Үгэн бус харилцаа (Non-Verbal communication)
3. Бичих (Written)

Харах (Visual) /Төрөл бүрийн видео, гэрэл зураг, эможи, хөдөлгөөнт GIF, инфографик, диаграм, дүрслэл /Illustrations/ (James, 2024)

Үгэн бус харилцааны хэрэглүүр нь (nonverbal communication, невербальные аспекты коммуникация) дараах үндсэн тэмдгийн системүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Оптик-кинетикийн систем (Дохио зангаа, нүүр царайны хувирал, биеийн хэлэмж)
2. Пара ба экстралингвистикийн систем (Паралингвистик нь дуу хоолойн өнгө, цар хүрээ, дэвсгэр зэрэг, экстралингвистикт ярианы завсарлага, хэмнэл, ханиах, инээх, уйлах зэрэг багтана)
3. Проксемика буюу харилцааны үед орон зайг зохион байгуулах
4. Визуальный контакт (А.Баяржаргал, 1998, хууд. 10) гэж үздэг байв.

Орчин үед үгэн бус харилцааны хэрэглүүрт дараах найман зүйл хамаарна гэж нарийвчлан үзэх болжээ. Үүнд:

1. Нүүрний хувирал (Facial expressions)
2. Дохио зангаа (Gestures)

3. Паралингвистик (дууны цараа, өнгө гэх мэт)
4. Биеийн хэл (Body language)
5. Проксемик буюу харилцагчийн хувийн орон зай (Proxemics or personal space)
6. Нүдний харц, мэдрэхүй (Eye gaze, haptics (touch))
7. Гадаад төрх (Appearance)

Өмсгөл зүүлт ба хэв маяг Artifacts (objects and images) (Cherry, 2023)

Эдгээрийг Э.Равдан “Тодорхой хэлний доторх эл “хэлүүдийг” орчин үеийн хэл шинжлэлд “хэлэхүйн төрөл”, “үүргийн найруулга” зэргээр томъёолдог” хэмээгээд “Энэ нь тухайн хэлээр харилцагч хүн бүрийн ухамсарт хадмал байх тул биеэ даасан, объектив шинжтэй байна. Жишээлбэл, ерийн яриа, албан бичиг, сонины өгүүлэл зэргийг хэлний бүрэлдэхүүн, найруулга зэргээр нь бид ялгаж чадаж байгаа нь дээрх шинжийн тод илрэл болно. Хэлэхүйн төрлүүд нь амьдралын аль нэгэн хүрээний тодорхой зорилгод үйлчлэх хэлний хэрэглүүрийг ашиглах, сонгох, нийлэмж бүтээх арга барилын нэгдлээрээ өөр хоорондоо давын өмнө ялгаатай. Өөрөөр хэлбэл, эл төрлүүд нь бүх нийтийн хэлийг ашиглах хэрэглээний хэв шинжүүд болохоос биш, тодорхой үг, үг хорших бүтэц, хэлбэр зэргийн жагсаалт огт биш юм. Тийм учраас эл төрлүүд нь бие биеэс үл шалтгаалах битүү хүрээ бус, харин хэлний хэрэглэхүүн чөлөөтэй дамжин нэвтэрдэг, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий харьцангуй бие даан зэрэгцэн оршсон хэлний тогтолцоо дахь тогтолцоо мөн (Э.Равдан, 1996, хууд. 5) хэмээн оновчтой тодорхойлжээ.

Нөгөөтээгүүр, Орчин үед хүн бүр нийгмийн сүлжээг ашиглан олон нийтэд үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх боломжтой болов. Ингэснээр хүмүүст олны өмнө ярих үед “Би юу ярих юм бэ?”, “Би ярьж чаддаггүй шүү дээ” гэх юм уу, эсвэл “Надад хэлэх үг алга” гэх үгийг санаатай, санамсаргүй хэлдэг байсан хандлага эрс өөрчлөгдөж, харин яавал эмх цэгцтэй, зөв, боловсон ярихад суралцах вэ гэдэг хүсэл тэмүүлэл, эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна. Энэ хэрэгцээ шаардлагын үүднээс хэлэхүйн төрөл зүйл, нэн ялангуяа үгэн харилцаа, аман хэлэхүй /ярианы хэл/-г нарийвчлан судалж, ЕБС болон их дээд сургуульд шинжлэх ухааны үүднээс заан сургах буюу энэ талын мэдлэг чадвар олгох шаардлага тулгарч байна.

Аман хэлэхүй /ярианы хэл/-г нарийвчлан судлахад цөөнгүй бэрхшээл байсаар ирсэн. Энэ талаар Ж.Баянсан “Орчин цагийн монгол хэлний судалгаа зохих өндөр түвшинд хүрч ирсэн ч гэсэн хэлний аливаа үзэгдлийг хэлэхүйн үүднээс шинжлэн тайлбарлах нь учир дутагдалтай явж ирснийг үгүйсгэх аргагүй. Монгол ярианы хэлийг тал бүрээс нь судалж, онцлог зүй тогтлыг нь тодорхойлсон явдал монгол хэлний хэлэхүйн түвшний судалгааны онгорхойг нөхөх нэг үндсэн тал болно (Ж.Баянсан, 1996, хууд. 77); Э.Равдан “Ярианы хэл” гэхлээр бичгийн хэлний төрлүүдтэй харшуулан түүнийг доод, хоёр дугаар зэргийн болгон “хэлмэгдүүлэх”, эсхүл “хар” тодотгол зүүж өөр дэд ухагдахуунтай хутган утга зохиолын хэлний гадна гарган “гадуурхах”, заримдаа бүр ярианы өвөрмөц тогтолцоо, түүнд үйлчилдэг хууль зарчмыг огоорсон “тулга тойрсон” хэмээн

хүрээг нь явцууруулахын аль аль нь шинжлэх ухааны ойлголт хараахан биш (Э.Равдан, 1996, хууд. 4) гэж байсан нь өнөө хэр үнэ цэнээ алдаагүй байна.

Мөн “Ярианы хэл судлах аргачлалын хувьд нэлээд төвөгтэй байдаг нь түүний дотоод өвөрмөц онцлогтой холбоотой. Тэрээр өөрийн жам ёсны шинж төрхөөрөө хүмүүсийн хамгийн ерийн, гаднын ямар ч нөлөөнд автаагүй харилцах орчин, нөхцөлд тодордог. Гаднын яльгүй ч атугай хүчин зүйл дээрх чанарыг алдуулдаг байна. Энэ нь нөгөөтээгүүр ярианы хэлний урсгал, аливаа нөхцөлд өгүүлэх санаа, илэрхийлэх хэрэглүүр нь бэлэн зэлэн, хэвшсэн шинжтэй байдагтай холбоотой. Тийм болохоор судалгаанд наад зах нь соронзон бичлэг хэрэглэх хүртэл төвөгтэй. Ярианы хэлний бичиж тэмдэглэсэн хэлбэр судалгааны эх сурвалж болгохын хувьд мөн учир дутагдалтай (Э.Равдан, 1996, хууд. 6) байдаг.


Бас дээр нь “Монгол хэл шинжлэлд үүргийн судлал хараахан газар авч төдийлөн хөгжөөгүй өнөө үед ярианы хэлтэй холбоотой нэр томьёо, ухагдахуун нэг мөр болоогүй (Э.Равдан, 1996, хууд. 6) хэвээр байна. Хамгийн наад зах нь монгол хэлний мэргэжлийн хүмүүс судалгаа шинжилгээний ажилдаа Письменная речь /рус/, Writting speech /eng/ -ийг “Бичгийн хэл”, Устный речь /рус/, Oral speech /eng/ гэсэн үгийг “Ярианы хэл” гэсээр байх уу? гэсэн асуулт тулгарна. Энэ тухай С. Нямсүрэн “Бичиг үсгээр бид харилцааны үүрэг гүйцэтгүүлдэг. Бичиг үсэгт бас соёл-үндэстний үүрэг бий. Гэхдээ бичиг үсэг бол хэл биш. Бичиг бол зөвхөн хэлийг төлөөлж байгаа юм” (С.Нямсүрэн, 1974, хууд. 29) , Э.Равдан “Ийм болзмол хүрээнд хүний нийгмийн харилцаанд байнга гарах нэг хэв шинж бүхий амьдралын нөхцөл дэх мөн хэв шинж бүхий хэрэгцээ, түүнийг даган хэлний хэрэглэхүүний давтагдах байдлаас шалтгаалж, хэвшмэл бэлэн загварууд (хэлбэр, бүтэц, үг гэх мэт) үүссэнийг “ярианы хэл”, “албаны хэл” гэх мэтээр нэрлэж заншжээ (Э.Равдан, 1996, хууд. 4-5) хэмээн тодорхой дурдсан байна. Э.Равдан багш уул өгүүлэлдээ ярианы хэл гэдэг нэр томьёог ямагт “ярианы хэл” хэмээн хашилтад бичсэн байдгийг дурдах нь зүйтэй. Н.Нансалмаа “Аман ярианы хэл” гээд “Аман ярианы зорилго нь өгүүлэгч сонсогчид хандаж мэдээлэл хурдан дамжуулах явдал. Харилцан яриа, олон хүний яриа, нэг хүний яриа хэлбэртэй (Н.Нансалмаа, 2019, хууд. 100) гэсэн бол сэтгэл судлаач Д. Санжжав Яриаг түүний чиглэлээр нь дотоод гадаад гэж хоёр ангилна. Гадаад яриаг Аман яриа, **Бичгэн яриа** /Письменная речь/ (Д.Санжжав, 1970, хууд. 102) хэмээсэн нь бас сонин юм. Энэ мэтчилэн Речь /рус/, Speech /eng/ хэмээх үгийг хэлний шинжлэлд Хэлэхүй хэмээн нэгэнт тогтсон бол сэтгэл судлалын ухаанд “Хэл яриа” (Б.Батсайхан, М.Дэлгэржав, 2015, хууд. 123), мөн заримдаа хэлний шинжлэлийн эрдэмтэд ч “культура речи” гэхийг “Хэлэхүйн соёл”, “Хэл ярианы соёл” хэмээн ялгавартайгаар хэрэглэсээр л байна. Бас дээр өгүүлсэн non verbal communication, (невербальные аспекты коммуникация) гэсэн үгийг сэтгэл судлалын ном бүтээлд хэлэхүйн бус харилцаа, хэл ярианы бус харилцаа гэж орчуулдаг бол хэл шинжээчид, тухайлбал: Ц. Сүхбаатар “Хэлний бус хэрэглүүр” (Ц.Сүхбаатар, Монгол хэлний найруулга зүй, 2009, хууд. 29), Ю.Мөнх-Амгалан “Үгэн бус харилцааны хэв маяг” гэх мэт өөр өөр нэр томьёо оноон хэрэглэсээр байна. Үүнийг цэгцлэх хэрэгтэй. Бид Устный речь /рус/, Oral speech /eng/ гэдгийг

Д.Батчулууны орчуулснаар цаашид **Аман хэлэхүй** гэх нь зөв гэж үзэж буй боловч сургалтын холбоотой зүйл хөндөж байгаа учраас, өмнө нэгэнт хэвшин тогтсоноор “Ярианы хэл” гэнэ.

Ярианы хэл (Аман хэлэхүй) гэж юу вэ гэдгийг эрдэмтэн судлаачид янз бүрээр тодорхойлсон байдаг. Тухайлбал: Э.Равдан “Ярианы хэл” гэж бүх нийтээр хүлээн зөвшөөрч мэдэрдэг, нийгмийн харилцааны тодорхой зорилгод захируулан аливаа үндэстний хэлний хэрэглэхүүнийг ашиглах, сонгох, үг хорших арга барилуудын дотоод нэгдэл бүхий цомыг хэлнэ (Э.Равдан, 1996, хууд. 5) гэсэн бол Д.Батчулуун “Аман хэлэхүй (Устний речь, Oral speech) нь цаг хугацаа, орон зайны хувьд нэг хэмжүүртэй байдаг ба энэ нь түүний усны урсгал лугаа нэг чиглэлийн шугаман хөдөлгөөн юм. Иймээс ярианы урсгал гэдэг хэллэг өргөн хэрэглэгддэг. Аман хэлэхүй нь цаг хугацааны хувьд салхины урсгал мэт хурдан явагдаад өнгөрдөг учир ярьж буй хүнд ярьж байгаа зүйл дээрээ анхаарлаа удаан тогтоон төвлөрүүлэх боломж олддоггүй (Д.Батчулуун, 2010, хууд. 6) хэмээсэн байдаг.


Ярианы хэлийг хэлэхүйн нэг хэлбэр, илэрхийлэх арга хэлбэрийн талаас ганцаарчилсан яриа (монолог), харилцан яриа (диалог), олны буюу олонд хандсан яриа (полилог) гэж ангилдаг. Харин хэрэглээ, утга зохиолын хэлэнд харьцах шинжээр нь хар яриа, боловсон яриа гэж хоёр ангилж болно (Д.Отгонсүрэн, 1979, хууд. 9) Бас үүргийн найруулга талаас дараах маягаар ангилдаг. Тухайлбал:

М.Н.Кожина найруулгын төрлийг дотор нь аман ба бичгийн хэлбэрээр нь:



(Ц.Сүхбаатар, Шинжлэх ухааны зохиолын найруулга, 1985, хууд. 19)

М.Базаррагчаа “Олонх ном зохиолд ярианы хэлийг найруулгын нэг төрөл хэмээн үзсээр ирсэн боловч ярианы хэл нь бичгийн хэлний найруулга шиг албан яриа ба эрдмийн яриа, дүрслэг яриа ба хар яриа гэж найруулгын өнгө аясаар ялгарна”



гээд (М.Базаррагчаа, 1995, хууд. 16) гэж ангилсан байдаг.

Өвөр Монголын судлаач **Содбилэг** “Үг ярих эрдэм” бүтээлдээ ярианы хэлийг ганцаар ярих, харилцан ярилцах хэмээх хоёр ангилаад дотор нь дараах маягаар ангилсан байдаг. Үүнд:

1. Ганцаар ярилцах хэлний боловсрол

- Уран тод унших
- Давтан ярих
- Зураг харж ярих
- Үлгэр хэлэх
- Аман яриагаар зохиол зохиох
- Тайлбарлан ярих
- Хурал цуглаанд үг ярих
 - Их хурал дээр үг ярих
 - Бага хурал дээр үг ярих
 - Дугуйлангийн хурал дээр үг ярих
- Баярын үгс ярих
 - Баяр хүргэх үгс
 - Насны өлзийн баярыг бэлэглэх үгс
 - Сархадын ерөөлийн үгс
- Хуримын ерөөлийн үгс
 - Гашуудлын үгс ярих

2. Харилцан ярилцах хэлний боловсрол

- Аман асуулт хариулт
- Харилцан ярилцах
- Шүүмжлэн ярилцах
- Дяньхуа /dian hua/ явуулах (Утсаар ярих)
- Тулган асуух

Маргалдан ярилцах

Сурвалжлах (Содбилэг, 1991) гэх мэтээр ангилж иржээ.


Өнгөрсөн хугацаанд эдгээр агуулгыг ЕБС-ын болоод их дээд сургуулийн сургалтын агуулгад хэрхэн багтааж ирснийг БСШУЯ-ны сайдын “Стандартын загварт өөрчлөлт оруулах тухай” 2006 оны 12 сарын 29-ны 481 тоот тушаалаар Мэргэжлийн бус ангийн сургалтын агуулгын ерөнхий суурь сонгон судлах Хүмүүнлэгийн ухааны хичээлд “Монгол хэлний найруулга зүй” 2 Багц цаг (Цаашид /Б.ц/ гэж тэмдэглэнэ) хичээл тусгасан, Монгол улсын засгийн газраас явуулж буй “Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого 2012-2016-ын хүрээнд БСШУ-ны сайдын 2014 оны 06 сарын 27 өдрийн “Хичээлийн жагсаалт батлах тухай” А/285 тоот тушаалаар “Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт”[БСШУ-ны сайдын 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/285 дугаар тушаалын хавсралт]-нд батлагдсан Монгол хэл бичиг, найруулга зүй (яриа бичгийн ур чадвар) -(3 б.ц) гэсэн хичээл орж эхэлснээс хойших хугацаанд хэвлэгдсэн сурах бичгүүд, сургалтын хөтөлбөрийг харьцуулан судалж, тогтоов. Үүнд:

1. Б.Бямбадорж, Монгол хэлний найруулга зүй, 2014, Ховд ИС
2. Л.Ганчимэг, М.Мөнгөнцэцэг “Монгол хэл бичиг, найруулга зүй” 2018 / МУИС/
3. Батжаргал нар Илтгэх урлагийн онол, арга зүй, 2019, МУИС пресс
4. Ц.Цогзолмаа, Б. Дэмбэрэлмаа, Хэл ярианы соёл, 2021, МУИС пресс
5. Г.Томтогтох нар Хэл ярианы соёл, 2019 *гурав дахь хэвлэл*, ШУТИС
6. Ш.Баттөгс, Хэрэглээний найруулга зүй ба найруулах эрдэмд суралцах нь, 2017, МУБИС
7. Г.Сүхбат, С.Батбаатар, Найруулах эрдэм, хэл ярианы соёл, 2007, СУИС
8. Г.Бямбацэрэн нар Монгол хэл бичиг, найруулга зүй, 2018, *3дахь хэвлэл* / МУБИС, БС/
9. Н.Уранчимэг, Д.Лхагвасүрэн, Найруулга зүйн онолын судалбар, 2013 / МУИС/
10. Н.Мөнхзориг, Зөв найруулан бичих арга ухаан, 2016, /Идэр дээд сургууль/
11. Д.Болод, Эх хэлний утга найруулгын хэлхээс, 2024, 8 дахь хэвлэл, /БХИС/
12. Б.Идэрбаяр, Монгол хэлний найруулга, соёл, 2024, Book Bind.club зэрэг сурах бичгийг хамрууллаа.

Эндээс хоёр зүйлийн ерөнхий дүгнэлт гарч байна. *Нэгдүгээрт*, Суралцахуйн зорилго, зорилт оновчгүй, сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгын дийлэнх хувийг бичгийн хэл найруулгад; үүн дотроо найруулгын төрөл зүйлийн талаарх онолын ойлголт, найруулгын алдаа, түүнийг засах, мөн зөв бичих, эсээ бичихэд зориулж байна. Энэ нь буруу зүйл биш боловч бичвэрт бус бичиж туурвих үйл ажиллагаанд хэр анхаарч байна гэдэг нэн чухал бөгөөд бид энэ тухай өмнөх өгүүлэлдээ бичсэн болно. Илтгэх урлагийн онол түүхээр дагнасан сурах бичгийн агуулга энд хамаарахгүй болно. *Хоёрдугаарт*, Багавтар хувийг эзэлж буй ярианы хэлний агуулгад; Риторика (Илтгэх урлаг), хэлэхүйн соёлын зарим зүйл, мэндлэх

хүндлэх ёсны тухай өгүүлжээ. Бидний дээр өгүүлсэн, ярианы төрөл зүйл, тухайлбал ганцаарчилсан болон харилцан ярианы тухай төдийлөн судалдаггүй байна. Зарим сурах бичигт энэ талын агуулга огт үгүй байгаа нь тухайн сурах бичгийн зорилго зорилт өөр байгаатай холбоотой нь тодорхой ч сурах бичиг гэдэг утгаар харвал ихэд өрөөсгөл юм. Ташрамд, Б.Идэрбаяр, Монгол хэлний найруулга, соёл, 2024 бүтээлийн хавсралт дахь найруулга зүйн 334 сорил нь сургалтын чухал ач холбогдолтойг дурдъя.

Харин бид уг чадварыг хөгжүүлэх, оюутан суралцагчдад энэ талын мэдлэг чадвар олгохын тулд уг хичээлийн суралцахуйн зорилго, зорилтыг оновчтой тодорхойлох ёстой, өмнөх сургалтын хөтөлбөрт дараах нэмэлт зорилтуудыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:



Ингээд суралцахуйн үйлийг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, хичээлийн цахим болон бусад эх сурвалжид ашиглахуйц агуулга, санал дүгнэлтийг ярианы төрөл тус бүрээр гаргав.

Нийтэд зориулсан яриа (Public speaking): Хүмүүсийн олон нийтэд хандаж хэлэх үг яриа буюу хурал цуглаан, баяр ёслолын элдэв арга хэмжээнд биечлэн болон зайнаас (online) оролцож ярихыг “Нийтэд зориулсан яриа” /Public speaking/ гэнэ. Нийтэд зориулсан яриаг эрдэмтэн судлаачид янз бүрээр ангилж ирсэн байдаг. Тухайлбал:

Диана Карлин (Diana Carlin, Saint Louis University), Жэймс Пайне (James Payne) нар Нийтэд зориулсан яриаг мэргэжлийн үг яриа “Specialized speech” гээд дотор нь

- Хүндэтгэлийн үг Courtesy speeches
- Баяр ёслолын үг (Ceremonial Speeches)
- Уралдаан тэмцээний үг (Contest Speeches) хэмээн 3 ангилаад

Хүндэтгэлийн үг

Баяр талархлын үг (Accepting awards and recognition)

Шагнал гардуулах үг (Presenting awards and recognition)

Танилцуулах үг (Introductions)

Баяр ёслолын үг

Мэндчилгээний үг (Inititions)

Төгсөлтийн баярын үг (Cradutions)

Дурсгалын үг (Dedications)

Эмгэнэлийн үг (Eulogies)

Уралдаан тэмцээний үг

Уран илтгэхүй (Original orations/oratory)

Бэлэн зэлэн яриа (Extemporaneous speeches)

Бэлтгэлгүй, гэнэтийн яриа (Impromptu speeches)

Эрдэм мэдлэг дэлгэрүүлэх яриа, лекц (Informative speeches) (Diana Carlin, James Payne, 1998, p. 432) ангилсан байдаг.

П.Увш, Б.Өлзийсүрэн нар “Монгол яруу өгүүлэхүйн ухаан, түүнд суралцах нь” бүтээлдээ:

- Ажил хэргийн яриа
- Олон нийтийн хурал, цуглаан дээрх яриа
- Парламентын яриа
- Дипломат яриа
- Баяр ёслолын яриа

Гашуудал эмгэнэлийн яриа хэмээн ангилаад (П.Увш, Б.Өлзийсүрэн, 2002, хууд. 44) тус бүр тодорхойлон бичсэн байдаг.

Ажил хэргийн яриа: Хамт олны өмнө, үйлдвэрлэлийн хурал, цуглаан дээр хэлнэ. Бэлтгэгдсэн, бэлтгэгдээгүй хэлбэртэй байна. Агуулга нь хэлэлцэж байгаа асуудалтайгаа дүйнэ. Хурал, цуглаан нээх, хаах үед хэрэглэгдэнэ. Хурлын үйл явцыг нэгтгэн дүгнэхэд хэрэглэнэ. Сайшаасан, урамшуулсан үнэлж цэгнэсэн байна. Нөхөрсөг, хамтын уур амьсгал бий болгоно.

Олон нийтийн хурал, цуглаан дээрх яриа: Хүний тоо олон, өмнө нь уулзаж учирч байгаагүй байна. Уриалан дуудсан, сэтгэлийг нь татсан арга хэрэглэнэ. Санаа бодлоо өөдрөг байдлаар тодорхойлно. Гүн дүн шинжилгээ, тайлан, нухацтай нотолгооноос зайлсхийнэ. Санаагаа ойлгуулахын тулд тодорхой үзүүлэн, лоозон хэрэглэнэ.

Парламентын яриа: Парламентын хуралдаан болон хууль тогтоох дээд шатны ажилд хэрэглэнэ. Илтгэл санал шүүмжид оролцох гэсэн хоёр хэлбэртэй. Улсын хэмжээний, эсвэл орон нутгийн хэмжээний ажлыг дэвшүүлж үг хэлдэг. Санаагаа хамгаалах, бусдыг няцаахдаа нухацтай бодлоготой, нотолгоотой хандана. Мэтгэлцээн хурцдах үе зайлшгүй гарна.

Дипломат яриа: Дипломат уулзалт, ярианы үед албан ёсоор хэрэглэнэ. Яриа болгоомжтой, урьдчилан харсан, төр, улсын ашигт нийцсэн байна. Утгын хувьд хоёрдмол нууцлагдмал байж болдог. Айх, догдлох, хулчийх явдал гаргаж болдоггүй. Сэтгэл хөдлөлөө ил гаргадаггүй.

Баяр ёслолын яриа: Албан ба албан бус ярианд хэрэглэдэг. Магтаал, хүндэтгэлийн баримт, мэдээ ашиглагддаг. Өмнө нь мэдэгдээгүй, гэхдээ бодитой баримт, мэдээ ашигладаг. Эерэг үнэлэлт, дүгнэлт гаргаж ярьдаг.

Гашуудал эмгэнэлийн яриа: Бүрлээчийн сайн сайхан, гавьяа зүтгэлийг нэрлэж ярьдаг. Хүн чанарынх нь сайн чанарын талыг заавал онцолдог. Албан

яриа, аар саар зүйлийг ярьдаггүй. Нэр төртэй энгийн яриа байх учиртай. Бидний хувьд, тэр хэн байв гэдэг асуултад хариулдаг. “De mortuis nihil nisi bene (эртний грек)” талийгаачийн талаар зөвхөн сайныг ярь, эсвэл юу ч бүү ярь. (П.Увш, Б.Өлзийсүрэн, 2002, хууд. 46) хэмээн тодорхойлж бичсэн байдаг.

Сүүлийн үед Нийтэд зориулсан яриаг Ёслол хүндэтгэлийн яриа (Ceremonial Speaking), Биечлэн үзүүлэн тайлбарлах яриа (Demonstrative Speaking), Эрдэм мэдлэг дэлгэрүүлэх яриа, лекц (Informative Speaking), Ухуулга сурталчилгааны үг яриа (Persuasive Speaking) гэж 4 ангилаад Ёслол хүндэтгэлийн яриа (Ceremonial speaking)-г дараах 8 зүйлд хуваан үзэх болсон байна.

1. Танилцуулах үг (Introductions)
2. Шагнал гардуулах үг (Presentations)
3. Талархлын үг (Acceptances) Ямар нэг шагнал, өргөмжлөл гардсаныхаа дараа хэлэх үг
4. Хүндэтгэлийн үг (Dedications, Tribute speeches, Graduation speeches, Wedding speeches) Байгууллагын нээлт, байшин барилгыг хэн нэгний нэрэмжит болгох, Төгсөлтийн баяр, Хурим найрт хэлэх үг гэх мэт
5. Хундаганы үг (Toasts)
6. Хошигнол (Roasts, After-Dinner Speeches)
7. Дурсгалын болон салах ёс гүйцэтгэхэд хэлэх үг (Farewells, Commemorative Speeches)
8. Эмгэнэлийн үг (Eulogies) (Special-Occasion Speeches, n.d.)

Тэгэхээр бид, их дээд сургуулийн Монгол хэл бичиг, найруулга зүй хичээлийн суралцахуйн зорилго зорилт, сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад дээрх ярианы төрлүүдийг заан сургах тодорхой санал дэвшүүлж байнгаа билээ.

ЕБС-ийн сургуулиас авхуулаад их дээд сургууль бакалавр, магистр, докторын сургалтаа дүүргээд, сургууль соёлын байгууллагаар 10-20 шахам жил сурч боловсорчхоод таван үг холбоод хэлэх чадваргүй мэргэжилтэн байж болохгүй. Мөн хурал цуглаан, баяр ёслолын элдэв арга хэмжээнд “Нар хур тэгширсэн... ээс авхуулаад дэвэн дэлхийн юм хамж шимж, 10-20 минут ярьчаад сая нэг юм гол юмаа ярьдаг тогтсон хэв маягаас салгах, эдгээрийг ойлгуулах, Нөгөөтээгүүр *Энэ шагналыг надад биш манай хамт олонд өгсөн шагнал гэж бодож байна. Би баярлалаа гэж хэлмээр байна. Ээждээ хайртай шүү гэж хэлмээр байна* хэмээх улиг болсон үгээ давтах, эсвэл Холливүүд ч юм уу гаднын баяр ёслолын үг хэллэгийг шууд хуулбарлан *Тэрэнд баярлалаа, Энэнд баярлалаа* гэхгүйгээр эдгээр үгсийг хэрхэн хэлэх арга зүйд суралцаж, чин сэтгэлээсээ үгээ хэлдэг болох зэрэг нь манай сургалцахуйн зорилт билээ.

Албан яриа: Сүүлийн үед хэл шинжлэлд хэлний хэрэглээний талын зарим ойлголтыг Linguistic Registers гэх ойлголтод хамруулж тайлбарлаж байна. Энэ тухай Б. Идэрбаяр “Английн судлаачид уран сайхны эхийн болон бусад харилцааны хүрээний найруулга гэсэн ойлголтыг хадгалан, “регистр” гэх нэр томъёог хэрэглэх болжээ. Регистр нь 1) харилцааны нөхцөл (байдал), 2) ярианы болон бичгийн хэлбэр, 3) харилцааны дүрийн бүтэц гэсэн хэд

хэдэн бүрэлдэхүүнийг багтаадаг. Жишээлбэл, албан бус аман ярианы регистр (Б.Идэрбаяр, 2024, р. 68) хэмээжээ.

Хэлшинжлэлийн “регистр”-ийн хамгийн чухал ойлголтын нэг бол албан (formal), албан бус (informal) ярианы хэлбэрүүд юм. Ямар ч хүн найз нөхөдтэйгөө ярих нэг өөрөөр, багштайгаа ярихдаа бас нэг өөрөөр буюу албан маягаар, хүндэтгэлтэй ярьдаг.

Монгол хэлний судлалд аман хэлэхүйн буюу ярианы хэлийг судлах судалгаа харьцангуй бага хийгдсэн тухай дээр дурдсан. Тиймээс бид энэ талын суралцахуйн зорилтыг хангахын тулд сургалтын хэрэглэгдэхүүн, албан уулзалт, албан хэргээ амжилттай болгохын тулд оюутан суралцагчид юу ярих, яаж ярих, юуг анхаарах вэ гэх зэрэг заавар зөвлөмжийг харилцааны онол, дипломат ёс ёслолын ном бүтээлээс олж үзэж байна. Тухайлбал:

Дипломатч Норовдайчин Чулууны Батжаргал “Төр төмбөгөр, ёс ёмбогор” бүтээлийнхээ Албан харьцаа гэсэн хэсэгт өгүүлснийг энд нэгж хичээлийн жишээ болгон оруулав.

Албан харьцаа

-Ярих гэсэн хүн чинь өөр ажилтай ч юм уу, өөр хүнтэй ярьж байвал харьцах гэж шамдах хэрэггүй, түүний завьг хар.

- “Та юу гэж бодож байна...” эсвэл “Та үүнийг сонссон уу...” ч гэх юм уу аль нэг эвтэй хэлбэрээр, өөрт нь хандсан байдлаар эхлэх нь зүгээр. Харин “Би”, “Надад ...” гэж эхлэхээс зайлсхийж сурах нь зүйтэй.

-Хэтэрхий олон үг завсар чөлөөгүй, түргэн урсгах нь таныг итгэл муутай, юманд ул суурь муутайхан ханддаг хүн гэсэн ойлголт төрүүлдэг.

-Бас хэтэрхий сунжруу удаан, үгээ зөөж тавьсан яриа залхуу хүргэж, таны тухай мэдрэмж муутай, ажил хэрэгч бус, назгай удаан гэсэн сэтгэгдэл үлдээнэ. Түр амсхийж, товч тодорхой ярих.

-Хүнийг онцгой хүсэлгүй байхад нь аливаа яриа маргаанд хүчээр оруулахгүй байхыг онцгойлох хэрэгтэй. Гэхдээ өөрийгөө зөв ойлгуулах үүднээс үзэл бодлоо сайн илэрхийлэх нь нэг хэлбэрийн урлаг мөн.

- Цагийг нь олж, хэрэгтэй газар нь хэлсэн тоглоом- шоглоом асуудлыг шийдэхэд чухал хэрэглүүр болдог. Бас нөгөө талаар түүнийг буруу хэрэглэвэл хэчнээн ч сайн тунгааж шүүсэн бэлтгэлийг тасалдуулж, бүгдийг нураадгийг санаж байх нь зүйтэй.

-Хэлэлцээний явцад нөлөөлж болох нэр хүнд бүхий ганц хүний нэрийг л хэлэхэд хангалттай үе ч байдаг. Хэрхэн нөлөөлөхийг нь мэдэхгүй олон томчуудыг нэрлэх нь тийм ч сайн үр дүнд хүргэхгүй.

-Харилцан ярилцагчийнхаа сэтгэлийн утсыг хөглөж, өөрийг нь яльгүй хөөргөх нь тодорхой үр дүнд хүрэх түлхүүр болдог ч удаа бий. “Таны зүтгэлтэйг мэддэгийн хувиар...”, “Та алив юмыг бүтээх гэж их шамддагийг мэддэг болохоор...”, “Энэ асуудлыг шийдэхэд таны хуримтлуулсан туршилага чухлыг

бодохоор...”, “Таны үнэт зөвлөгөө л үүнийг гүйцэлдүүлэхэд тус болно гэж бодоод...” гэх мэт тухайн хүнд тал зассан сэтгэлээ илэрхийлэх...

-Ярьж байгаа хүнийхээ алдар нэр, албан тушаал, цол хэргэмийг сайн мэдэж, зөв хэрэглэх чухал...

-Сайн танилцаагүй байж, хүнд хэтэрхий дотносох нь долигносон, эсвэл өөрийгөө “доош хийсэн” болно.

-Хэзээ ч хүндэтгэлтэй, найрсаг, ая дантай, чин сэтгэлээсээ, дипломатч байдлаар ярьж буй хүндээ хандаж байхыг хичээгээрэй... (Ч.Батжаргал, 2010, хууд. 94-95).

Мөн Д.Цолмон дипломат ажлын дийлэнх нь албан бичиг хэрэг боловсруулах хийгээд албаны яриа, хэлэлцээ хийхэд зарцуулагддаг хэмээгээд “Олон түмний уншдаг нийтийн хэвлэл мэдээлэл элдэв хачиртай уянгын халилтайгаар утга санааг илэрхийлдэг бол дипломат бичиг баримт нь албаны, баримт болон үлдэх, тухайн улс орны байр суурийг илтгэсэн байдаг учраас түүнд хөнгөн хуудуу хандаж болдоггүй. Сэтгэлийн хөдлөл, ундууцлаа шууд илэрхийлэхгүйгээр нухацтай боловсруулах учиртай юм. Дипломат хэллэг нь даруу, хянуур, эелдэг мөртлөө асуудлаа нягт нарийн боловсруулсан байхыг шаардана. Зөв үг хэллэгээр, мэргэжлийн өндөр түвшинд санаа бодлыг оновчтой илэрхийлсэн байвал зохино” (Д.Цолмон, 2010, хууд. 139) гэж дипломат хэл ярианы онцлогийн тухай бичсэн байна. Зөвхөн олон улсын харилцааны чиглэлээр мэргэжил эзэмшиж буй оюутнууд гэлтгүй, бүхий л хүн бусадтай соёлтой, сайхан харилцах шаардлагатай тул энэ талын мэдлэг эзэмших ёстой.

Эндээс харахад, бид нийгэм цаг үеийн онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан, энэ чиглэлийн судалгаа шинжилгээ хийх, албан яриа болон дипломат үг хэллэг, түүний соёлыг сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад багтаах нь чухал гэдэг нь тодорхой байна.

Өдөр тутмын яриа: Хүний өдөр тутмын ярианд ийм байх ёстой, тийм байх ёстой гэсэн хатуу шалгуур тогтоох боломжгүй ч гэсэн хэлэхүйн соёлын асуудлыг энд ярих ёстой. Хэлэхүйн соёл (Хэл ярианы соёл), хэл ярианы хэм хэмжээний талаарх агуулгыг бидний судалгаанд хамруулсан бүтээлүүдэд харьцангуй багтаасан нь сайшаалтай. Ялангуяа, Г.Томтогтох нарын “Хэл ярианы соёл”, 2019 *гурав дахь хэвлэл, /ШУТИС/ номын Нэгдүгээр бүлэг*. Хэл ярианы соёл, хэлний боловсрол, *Хоёрдугаар бүлэг*, Мэндлэх хүндлэх, талархах, зэмлэх, цээрлэх ёс заншил, үг хэллэг, *Гуравдугаар бүлэг*, Ярианы найруулга (Томтогтох нар, 2019, хууд. 14-88) гэсэн 3 бүлэг буюу нийт номын 30-40% энэ агуулгыг хамарчээ.

Өдөр тутмын яриан дээр онцлон анхаарах хоёр зүйл бол, *нэг нь* мэндлэх ёс, *нөгөө нь*, бүдүүлэг үгийн хэрэглээний асуудал юм.

Монголчууд мэндлэх хүндлэх ёсны арвин баялаг сантай нь чухал ч хүнтэй мэндлэхгүй явдал ихэсч буй нь тун харамсалтай бөгөөд бидний сургалтын агуулга үүнд чиглэх ёстой. Хүнтэй мэндэлж сураагүй, сургаагүй тохиолдолд ярих чадварын тухай ярилтгүй юм. Бүдүүлэг үгийг их хэрэглэж байгаа талаар

миний бие “Хэлэхүйн соёлын тулгамдсан асуудал” гэсэн илтгэл тавьж, өгүүлэл нийтлүүлсэн тул энд олон зүйл нурших нь илүүц буй за.

Тайзны яриа: Сүүлийн үед янз бүрийн шалтгааны улмаас хэл ярианы болон харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд олширч байгаа нь сургуулийн өмнөх болон бага боловсролын байгууллага, багш нарын өмнө тулгарах том асуудал болсон. Үүнийг багаас нь засахгүй бол хэл ярианы согог болж тогтох эрсдэлтэй тул мэргэжлийн хэл засалч эмч нарт хандах ёстой. Өөр нэг зүйл бол, хүүхэд залуучууд ярихдаа дуу маш сул, аман дотроо бувтнах байдал нийтлэг байна. Монголчууд эртнээс хүний урдаас хараад хурц тод мэндэлдэг, цоглог сайхан ярьдаг байхыг чухалчилдаг байсан. Тиймээс хүүхдийн хэл яриаг багаас нь түргэн хэллэг, ес хэлэлцэх үг зэрэг үгэн наадгайгаар тоглуулангаа засаж, хөгжүүлдэг байв. СӨБ болон бага сургуульд хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, хурц тод ярьж сургах нэг чухал арга бол уншуулах, түүн дотроо уран тод уншуулах арга билээ. Ерөнхий боловсролын сургуульд энэ аргыг байнга хэрэглэж байх нь зөв юм.

Харин их дээд сургуулийн оюутнуудын хувьд, ялангуяа соёл урлагийн мэргэжлийн оюутнуудад тайзны ярианы хичээлийг 1959 онд УБДС-д кино драмын жүжигчин бэлтгэж, хөтөлбөрт тайзны ярианы сургалт орж эхэлснээс хойш зааж эхлээд 60 гаруй жил болж байна. 1990 онд СУИС байгуулагдаж, 1994 онд Тайзны ярианы тэнхим байгуулагдсанаар улам бүр системтэй заах болжээ.

Тайзнаас ярих гэгч нь энгийн юм шиг хэр нь ихээхэн төвөгтэй, ур чадвар, цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардсан ажил байдаг. XIX зууны дунд үеэс эрчимтэй хөгжиж эхэлсэн энэхүү “Тайзны яриа” нь өнөөдөр олон шинжлэх ухаануудын уулзварт судлагдаж, уялдаа холбоо шинэ шинэ нээлтүүд, эрэл хайгуулаар улам баяжин, төгс төгөлдөр болсоор байна. (П.Мөнх-Од, 2010, хууд. 138)

Энэ тухай ардын жүжигчин Н.Сувд “Театрын урлагт ярианы хэлийг гол үндэс болгон хэрэглэдэг. Жүжигчид нь зохиолчийн цаасан дээр бичсэн зохиолыг яриан хэлд шилжүүлэн байж тайзан дээр дүрийг бодитой амьд болгон тоглодог. Учир нь ярианы хэлээр хүмүүс хоорондоо ойлголцож, харилцааны хэрэглэгдэхүүн болгож байдгийн хувьд тайзан дээр бичгийн хэлээр дүрүүд яриад эхэлбэл жүжигчний тоглолтын гол зорилго болох үзэгчдэд итгүүлэх зорилго алдагдана” (Н.Сувд, 2011, хууд. 23) хэмээсэн байдаг.

Эндээс, бичгийн хэлийг ярианд шилжүүлэх, мөн ярьсан зүйлээ бичигт хөрвүүлэх чадварын асуудал хамгийн чухал юм. Оюутан сурагчдын ярих чадварыг илүү сайн хөгжүүлэхийн тулд энэхүү судлагдахууныг хэл, утга зохиол, нийгэм хүмүүнлэгийн салбарын оюутнуудад судлуулахад болохгүй зүйл үгүй юм.

Нөгөө талаас “Илтгэх урлаг” /Rethoric/-ийн сургалтын агуулгыг тайзнаас ярих урлагтай холбож, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах нь илүү үр дүнтэй юм. МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхим, Утга зохиолын нэгдэл болон СУИС-ийн Ярих урлагийн тэнхимтэй хамтран их дээд сургуулийн оюутнуудын дунд уламжлал жил болгон зохион байгуулдаг “Давалгаа” богино өгүүллэгийн наадам үүний нэг тодорхой жишээ билээ.

Дүгнэлт

Өнгөрсөн хугацаанд бид оюутан суралцагчдын ярих ур чадварыг хангалттай хөгжүүлж ирээгүй нь бидний хэрэглэж буй сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, хүмүүсийн бодит харилцаанаас харагдаж байна. Иймд энэ чиглэлийн хичээлийн суралцахуйн зорилго, зорилтыг оновчтой болгох үүднээс ярианы дараах төрлүүдийг их дээд сургуулийн монгол хэл, бичгийн сургалтын агуулгад багтаах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд: Нийтэд зориулсан яриа, албан яриа, өдөр тутмын яриа, тайзны яриа зэрэг болно. Мөн суралцахуйн үйлийг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, хичээлийн цахим болон бусад эх сурвалжид эдгээр агуулга ямар байдлаар тусаж болохыг жишээ баримтуудыг орууллаа.

Ном зүй

- Баяржаргал, А. (1998). Харилцааны хэлэхүйн бус хэрэгслээр сэтгэлийн хөдөлгөөнийг таних зарим асуудал. Улаанбаатар хот.
- Батсайхан, Б. Дэлгэржав, М. (2015). Сэтгэл судлалын толь бичиг. Улаанбаатар хот.
- Баатархүү, Ц. (2011). Зөв ярих ухаан. Улаанбаатар хот: Битпресс ХХК.
- Баянсан, Ж. (1996). Монгол ярианы хэлний тогтвортой хам хэллэгийн үүргийн ангилал. In МУИС, Монгол ярианы хэл (pp. 77-82). Улаанбаатар хот.
- Баянсан, Ж. Одонтөр, Ш. (1995). Хэл шинжлэлийн нэг томъёоны зүйлчилсэн тайлбар толь. Улаанбаатар хот.
- Базаррагчаа, М. (1995). Ярианы хэлний ганцжиж утгажсан үгийн тухайд. МУИС, Монгол ярианы хэл (р. 16). Улаанбаатар хот.
- Батчулуун, Д. (2010). Төрөлх хэлээр яригчийн хэлэхүйн алдааны сэтгэц-хэлшинжлэлийн тайлбар. ХИС ГХСС Эрдэм шинжилгээний бичиг (pp. 6-11). Ховд аймаг.
- Батжаргал, Ч. (2010). Төр төмбөгөр Ёс ёмбогор. Улаанбаатар хот.
- Идэрбаяр, Б. (2024). Монгол хэлний найруулга, соёл. Улаанбаатар хот: Book Bind.club
- Мөнх-Од, П. (2010). Тайзны яриаг уран зохиолтой холбох нь. Эрдэм судлалын бичиг (р. 138). Улаанбаатар хот: Бемби Сан ХХК.
- Нямсүрэн, С. (1974). Хэл, хэлэхийн учир. Улаанбаатар.
- Нансалмаа, Н. (2019). Нийгэм хэл шинжлэл. Улаанбаатар хот: МУИС пресс.
- Отгонсүрэн, Д. (1979). Ярианы найруулга, соёл. Улаанбаатар хот.
- Оч нар. (2015). Монгол аман зохиолын удиртгал. Улаанбаатар хот. Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Мөнхбаяр
- Равдан, Э. (1996). Ярианы хэл үүргийн хэл шинжлэлийн ухагдахуун болох нь. In МУИС, Монгол ярианы хэл (pp. 3-13). Улаанбаатар хот.
- Санжжав, Д. (1970). Сэтгэл судлал. Улаанбаатар хот.
- Содбилэг. (1991). Үг ярих эрдэм. (Оюунгэрэл монголчлон найруулав) Хөх хот.
- Сувд, Н. (2011). Тайзнаас ярих урлаг ба нийтийн хэл ярианы соёлын холбоо. In Театрын хэл яриа (р. 23). Улаанбаатар хот: Монгол улсын төрийн хэлний зөвлөл.
- Сүхбаатар, Ц. (1985). Шинжлэх ухааны зохиолын найруулга. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар.
- Сүхбаатар, Ц. (2009). Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар хот: Удам соёл.
- Томтогтох нар. (2019). Хэл ярианы соёл. Улаанбаатар хот: ШУТИС.
- Увш, П. Өлзийсүрэн, Б. (2002). Монгол яруу өгүүлэхүйн ухаан, түүнд суралцах нь. Улаанбаатар хот.
- Цолмон, Д. (2010). Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК
- Diana Carlin, James Payne. (n.d.). Public Speaking Today.
- Cherry, K. (2023 оны 2 22). Types of Nonverbal Communication. verywellmind.com: <https://www.verywellmind.com/types-of-nonverbal-communication-2795397>-ээс Гаргасан
- James, C. (2024 оны 2 12). The 4 Types of Communication – Definitions and Examples. colinjamesmethod.com: <https://colinjamesmethod.com/the-4-types-of-communication/>-ээс Гаргасан

Library. <https://open.lib.umn.edu/publicspeaking/chapter/18-2-special-occasion-speeches/>
Tsoomoo. (2022). Харилцан яриа ба ганцаардал. <https://www.blindcare.mn/blog/133>

Abstract

There is a need to thoroughly study the different types of oral speech from the perspective of applied linguistics. In addition, it is advisable to improve students' speaking skills by identifying the types of oral speaking appropriate for the teaching process and incorporating them into the curricula and textbook content. In particular, strategies for teaching public speaking - a skill increasingly required in today's society - as well as formal and informal speaking will be explored, in line with the learning goals and objectives of this subject area.